



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/495

Чойбалсан

Г

Комисс байгуулах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 03/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжих "Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх" ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Д.Мөнхбаяр

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичиг:

Л.Өнөрхишиг

-Гүйцэтгэгчийг төлөөлж "Сансинус"ХХК-ийн менежер

Гишүүд:

Г.Баярсайхан

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Ч.Шинэцэцэг

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн Бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Гансүмбэр

-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Өвсийг хүлээж авах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад урьдчилан танилцуулсны дараа дүгнэлтийг баталгаажуулахыг Комиссын дарга (Д.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЕЛ